



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/110/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## **Агуулга**

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын ТАЙЛАН .....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/121  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020386

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,371,636.00</b>	<b>31,666,436.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>26,371,636.00</b>	<b>31,666,436.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,939,800.00</b>	<b>2,894,800.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	2,759,800.00	2,759,800.00
35130	Эм боох материал	180,000.00	135,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>23,431,836.00</b>	<b>28,771,636.00</b>
35410	Бичиг хэргийн материал	756,210.00	1,426,710.00
35420	Аж ахуйн материал	12,269,470.00	13,987,020.00
35460	Хүнсний материал	469,180.00	2,947,330.00
35470	Бусад хангамжийн материал	9,936,976.00	10,410,576.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>419,845,614.84</b>	<b>397,316,288.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>419,845,614.84</b>	<b>397,316,288.34</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>411,659,114.58</b>	<b>389,157,288.06</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	389,554,200.00	389,554,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,773,618.90)	(50,152,706.70)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,417,081.00	70,417,081.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,780,341.96)	(50,970,259.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,864,019.00	29,864,019.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,774,074.55)	(20,758,496.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,439,000.00	27,439,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,287,150.01)	(6,235,550.01)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,186,500.26</b>	<b>8,159,000.28</b>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(357,499.74)	(384,999.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,994,000.00	7,994,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>446,217,250.84</b>	<b>428,982,724.34</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>446,217,250.84</b>	<b>428,982,724.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>446,217,250.84</b>	<b>428,982,724.34</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,913,084.00	52,913,084.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>360,063,294.24</b>	<b>342,828,767.74</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	376,822,460.12	360,063,294.24
51220	Тайлант үеийн үр дүн	(16,759,165.88)	(17,234,526.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,240,872.60	33,240,872.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>446,217,250.84</b>	<b>428,982,724.34</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>265,326,500.00</b>	<b>213,121,850.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,499,000.00</b>	<b>221,650.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,499,000.00</b>	<b>221,650.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,499,000.00	221,650.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,000,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>260,827,500.00</b>	<b>212,900,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>216,292,700.00</b>	<b>192,180,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,292,700.00	192,180,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>24,798,900.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,798,900.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,735,900.00</b>	<b>20,719,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,735,900.00	20,719,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>281,885,666.07</b>	<b>230,356,376.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>281,885,666.07</b>	<b>230,356,376.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>204,285,877.24</b>	<b>197,106,713.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>130,463,109.72</b>	<b>127,864,737.80</b>
210101	Үндсэн цалин	86,096,205.70	118,541,403.30
210102	Нэмэгдэл	24,524,452.54	1,092,259.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,529,641.00	0.00
210104	Урамшуулал	16,312,810.48	8,231,075.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,824,812.45</b>	<b>17,889,290.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,841,880.05	12,680,759.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,310,106.63	1,373,347.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,110,549.22	1,024,757.81
210204	Ажилгүйдлийн даатгал	216,673.09	248,531.76
210205	Эрүүл мэндийн даатгал	2,345,603.46	2,561,894.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,136,179.00</b>	<b>18,710,009.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,864,330.00	2,776,923.00
210302	Түлш, халаалт	14,746,369.00	15,730,736.00
210303	Цэвэр, бохир ус	525,480.00	202,350.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>652,120.00</b>	<b>1,925,250.00</b>
210401	Бичиг хэрэг	93,200.00	79,500.00
210402	Тээвэр, шатахуун	198,920.00	196,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	418,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	290,000.00	1,031,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,438,945.00</b>	<b>6,085,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	90,000.00
210502	Хоол, хүнс	11,288,945.00	5,995,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>462,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	462,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>74,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	74,000.00	0.00

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>714,000.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	714,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,482,711.07</b>	<b>24,169,826.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	499,500.00	1,030,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	610,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,488,211.07	22,529,326.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>77,599,788.83</b>	<b>33,249,662.55</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,798,900.00</b>	<b>0.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,443,900.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,355,000.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,099,721.00</b>	<b>1,512,741.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,721.00	1,512,741.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,701,167.83</b>	<b>31,736,921.55</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,701,167.83	31,736,921.55
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(16,559,166.07)</b>	<b>(17,234,526.50)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>199,999.81</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	199,999.81	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(16,759,165.88)</b>	<b>(17,234,526.50)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>52,913,084.00</b>	<b>33,292,568.60</b>	<b>376,770,764.12</b>	<b>462,976,416.72</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	51,696.00	51,696.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,913,084.00	33,292,568.60	376,822,460.12	463,028,112.72
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(16,759,165.88)</b>	<b>(16,759,165.88)</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>52,913,084.00</b>	<b>33,240,872.60</b>	<b>360,063,294.24</b>	<b>446,217,250.84</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>52,913,084.00</b>	<b>33,240,872.60</b>	<b>360,063,294.24</b>	<b>446,217,250.84</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(17,234,526.50)	(17,234,526.50)
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>52,913,084.00</b>	<b>33,240,872.60</b>	<b>342,828,767.74</b>	<b>428,982,724.34</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>260,827,500.00</b>	<b>212,900,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>260,827,500.00</b>	<b>212,900,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>216,292,700.00</b>	<b>192,180,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,292,700.00	192,180,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>24,798,900.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,798,900.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,735,900.00</b>	<b>20,719,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,735,900.00	20,719,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>260,827,500.00</b>	<b>212,900,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>260,827,500.00</b>	<b>212,900,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>183,227,711.17</b>	<b>179,650,537.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>130,570,809.72</b>	<b>127,864,737.80</b>
210101	Үндсэн цалин	86,203,905.70	118,541,403.30
210102	Нэмэгдэл	24,524,452.54	1,092,259.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,529,641.00	0.00
210104	Урамшуулал	16,312,810.48	8,231,075.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,824,812.45</b>	<b>17,889,290.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,841,880.05	12,617,759.53
210202	Тэтгэмжийн даатгал	1,310,106.63	1,398,547.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,110,549.22	1,034,837.84
210204	Ажилгүйдлийн даатгал	216,673.09	251,051.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,345,603.46	2,587,094.26
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,136,179.00</b>	<b>18,706,659.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,864,330.00	2,776,923.00
210302	Түлш, халаалт	14,746,369.00	15,730,736.00
210303	Цэвэр, бохир ус	525,480.00	199,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,608,920.00</b>	<b>3,030,800.00</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	198,920.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	294,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,190,000.00	1,586,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,950,390.00</b>	<b>10,018,550.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	45,000.00
210502	Хоол, хүнс	10,405,390.00	8,473,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,499,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>74,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	74,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>714,000.00</b>	<b>0.00</b>

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	714,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,848,600.00</b>	<b>1,640,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,211,600.00	1,030,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	637,000.00	610,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>77,599,788.83</b>	<b>33,249,662.55</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,798,900.00</b>	<b>0.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,443,900.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,355,000.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,099,721.00</b>	<b>1,512,741.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,721.00	1,512,741.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,701,167.83</b>	<b>31,736,921.55</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,701,167.83	31,736,921.55
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>212,900,200.00</b>	<b>179,650,537.45</b>	<b>33,249,662.55</b>	84.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>212,900,200.00</b>	<b>179,650,537.45</b>	<b>33,249,662.55</b>	84.4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>212,900,200.00</b>	<b>179,650,537.45</b>	<b>33,249,662.55</b>	84.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>149,352,300.00</b>	<b>127,864,737.80</b>	<b>21,487,562.20</b>	85.6
210101	Үндсэн цалин	99,606,600.00	118,541,403.30	-18,934,803.30	119.0
210102	Нэмэгдэл	28,065,900.00	1,092,259.41	26,973,640.59	3.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,720,000.00	0	5,720,000.00	-
210104	Урамшуулал	15,959,800.00	8,231,075.09	7,728,724.91	51.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,162,500.00</b>	<b>17,889,290.65</b>	<b>2,273,209.35</b>	88.7
210201	Тэтгэврийн даатгал	14,188,500.00	12,617,759.53	1,570,740.47	88.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,493,500.00	1,398,547.24	94,952.76	93.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,194,800.00	1,034,837.84	159,962.16	86.6
210204	Ажилгүйдлийн даатгал	298,700.00	251,051.78	47,648.22	84.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,987,000.00	2,587,094.26	399,905.74	86.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,219,400.00</b>	<b>18,706,659.00</b>	<b>1,512,741.00</b>	92.5
210301	Гэрэл, цахилгаан	3,962,000.00	2,776,923.00	1,185,077.00	70.1
210302	Түлш, халаалт	15,730,700.00	15,730,736.00	-36.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	526,700.00	199,000.00	327,700.00	37.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,040,000.00</b>	<b>3,030,800.00</b>	<b>9,200.00</b>	99.7
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	50,000.00	650,000.00	-600,000.00	1,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	294,000.00	6,000.00	98.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	1,586,800.00	603,200.00	72.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,877,000.00</b>	<b>10,018,550.00</b>	<b>7,858,450.00</b>	56.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	45,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	16,332,000.00	8,473,750.00	7,858,250.00	51.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,499,800.00	200.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>0</b>	<b>100,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	100,000.00	0	100,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,649,000.00</b>	<b>1,640,500.00</b>	<b>8,500.00</b>	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,037,000.00	1,030,000.00	7,000.00	99.3

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	612,000.00	610,500.00	<b>1,500.00</b>	99.8
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>212,900,200.00</b>	<b>192,180,800.00</b>	<b>20,719,400.00</b>	90.3
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>192,180,800.00</b>	<b>192,180,800.00</b>	<b>0.00</b>	100.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	192,180,800.00	192,180,800.00	<b>0.00</b>	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20,719,400.00</b>	<b>0</b>	<b>20,719,400.00</b>	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	<b>0.00</b>	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	<b>0.00</b>	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>0.00</b>	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	<b>0.00</b>	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	<b>0.00</b>	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	<b>0.00</b>	100.0
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>85.00</b>	<b>85</b>	<b>0.00</b>	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	85.00	85	<b>0.00</b>	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>24,798,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>24,798,900.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		24,798,900.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		24,798,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,443,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,355,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		24,798,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		24,798,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,798,900.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>00.00</b>

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 260,026.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,600.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,820.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 230,356.4 мянган төгрөгийн 0.7 хувиар буюу 1,612.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 212,900.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

#### **Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 31,666.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 397,316.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,671.0 мянган төгрөгөөр буурч өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	26,371.6	31,666.4	5,294.8
Үндсэн хөрөнгө	419,845.6	397,316.3	(22,529.3)
Нийт хөрөнгө	<b>446,217.3</b>	<b>428,982.7</b>	<b>(17,234.6)</b>
ЗГ-н оруулсан капитал	52,913.0	52,913.0	-
Хуримтлагдсан үр дүн	360,063.3	342,828.7	(17,234.6)

Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	446,217.3	428,982.7	(17,234.6)
--	-----------	-----------	------------

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын данс өмнөх оноос 5,294.8 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал, аж ахуйн материалын үлдэгдлээс голлон шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 22,529.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 268,634.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,719.4 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 289,354.3 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 76,454.1 мянган төгрөгөөр бууруулан 212,900.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 20,719.4 мянга, улсын төсвөөс 192,180.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 192,180.8 мянга, орон нутгийн төсвөөс 20,719.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 179,650.6 мянган төгрөгийг зарцуулж, 33,249.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 212,900.2 мянган төгрөг буюу 84.4 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 21,487.6 мянга, хоол хүнсний зардлыг 7,858.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардалд нийт 24,798.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 16,443.9 мянган, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зардалд 8,355.0 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сургуулийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд

зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 84.4 хувийн биелэлттэй, буюу төсвийг хэмнэлтэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийг бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж үндсэн цалин хөлсийг 19.0 хувиар буюу 18,934.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 194,540.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгахад шалгагдагч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54.5 дэх заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11,808.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

##### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11,808.0 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

##### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Баян сумын Хүүхдийн цэцэрлэг	2	11,808.0							2	11,808.0
	ДҮН	2	11,808.0							2	11,808.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)